





байна.

Кадастрын чиглэлээр:

2018 оны 05 сарын 22-ны байдлаар 2016-2017 онд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилсөн өмчлөх эрхээ баталгаажуулахыг хүссэн нийт 392 иргэний өмчлөлийн мэдээллийг “Лэнд менежер” програм хангамжинд оруулан кадастрын зургийг баталгаажуулан гаргаж өгсөн.

Газрын төлбөрийн орлого:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 08 дугаар тогтоолоор 2018 онд 132 сая төгрөгийг аймгийн орлогод төвлөрүүлэхээр батлагдсан. 2018 оны 05 сарын 22-ны байдлаар газрын төлбөрийн орлого нийт 64 сая төгрөг буюу 48.5 хувийг төвлөрүүлээд байна



Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөл:

Газар өмчлөх материалыг 266 иргэнд гэр хорооллын газрын хянан баталгааг гарган, захирамжийг хуулбарлан кадастрын зургийн хамт хүлээлгэн өглөө. Урьд нь газраа гэр бүлийн хэрэгцээнд дундаа өмчлөн авсан 27 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн Засаг даргын захирамж гаргууллаа.

Газрын харилцааны болон бүтээн байгуулалтын ажлыг иргэдэд таниулах, сурталчлах үйлчилгээг ойртуулах зорилгоор Сүмбэр сумын 1, 4, 5, 6 дугаар багийн өдөрлөгт газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, газрын даамал нар оролцон иргэдэд газрын багц хуулийн талаар холбогдох мэдээлэл, газрын тухай ойлголт өгөхийн зэрэгцээ нийт 108 гарын



авлага, газар өмчилж авсан иргэдийн материалыг тараах, газрын төлбөрийг хураах ажлыг зохион байгууллаа.

Геодези, зураг зүйн чиглэлээр:

Хэмжилт зураглалын ажлаар 5 дугаар сард нийт 5 иргэний эзэмшил өмчлөлийн газрыг газар дээр нь хэмжилт хийн эргэлтийн цэгийн тэмдэгжүүлэн хүлээлгэн өгсөн. Мөн газрын маргаан хяналтын хэмжилтээр дараах газрууд дээр хэмжилт хийсэн. Үүнд:

1. Говийн сондор эмийн сан
2. Төмөр замын байрны 40-1 тоот
3. Төмөр замын баирны 36-1 тоот
4. САА-н хотхон 24 тоот
5. САА-н хотхон 23 тоот

Төлөвлөлт хариуцсан мэргэжилтэнтэй хамтран САА-н хотхон, тээвэрчдийн байр, 4, 5 дугаар байрын тоглоомын талбайн цэвэр бохирыг газрыг нэг бүрчлэн хэмжилт хийж мэдээллийн санд оруулаад байна.

Байгууллагын санал гомдол хүлээн авах 9554-3387 дугаарт иргэдээс ирүүлсэн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газраас дур мэдэн сунгасан тухай санал гомдлын дагуу дараах газруудад мэдэгдэл өгч газар дээр нь очиж ажилласан байна.

- Лүнгийн 16 тоот
- Говийн сонд эмийн сан
- САА-н хотхон иргэн Буяндэлгэр, Баярцэнгэл

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуй, барилгын материалын чиглэлээр:

1. “Орон нутгийн барилгын компаниудын өрсөлдөх чадавхийг сайжруулах нь” сэдэвт Барилгын удирдах ажилтны зөвлөгөөнийг Дорноговь, Говьсүмбэр аймгийн барилгын салбарын компаниудыг оролцуулан хамтарсан байдлаар 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Сайншанд хотноо амжилттай зохион байгуулсан. Тус зөвлөгөөнийг аймгийн ЗДТГазар, ГХБХБГазар зохион байгуулсан ба зөвлөгөөнд Дорноговь аймгийн нийт 18 аж ахуйн нэгж байгууллагын 28 хүн, Говьсүмбэр аймгийн 6 аж ахуйн нэгж байгууллагын 14 хүн, нийт 24 аж ахуйн нэгж байгууллагын 42 хүн оролцсон.



2. АЗДТГазрын ХОХБТХэлтэс, ГХБХБГазрын БХБХэлтэс, ХХААГазар хамтран Сумдын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн нарт төсөв санхүүгийн төлөвлөлт, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад авах дүрмийн танилцуулга, барилгын ажлын явцад захиалагч болон гүйцэтгэгчийн анхаарах асуудал, холбогдох хууль дүрмийн танилцуулга, цахим тендерийн танилцуулга зэрэг сэдвээр мэдээлэл, сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 07-ний өдөр зохион байгууллаа.



Хот байгуулалтын чиглэлээр:

Дараах ажлуудын төсөв тооцоог гаргасан:Үүнд:

- - Сүмбэр сумын 1-р баг,цэвэр бохир усны шугамын ажилд газар дээр нь хэмжилт хийж, ажлын төсөв тооцоог гаргасан.
 - Байгаль орчины газрын захиалгаар хийгдэх нийтийн бие засах газар, хогийн савны ажил
 - “Найрамдал хотхон”-ны самбарын тохижилтын ажил
 - Сүмбэр сумын 1-р баг, цэвэр бохир усны шугам сүлжээний ажилд газар дээр нь хэмжилт хийж, төсвийн тооцоолол гаргах ажил
- 2 .Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төвийн барилгын ажлын зургийн даалгавар боловсруулсан.
- 3 Шивээговь сумын “Цэвэрлэх байгууламж”-ийн судалгаа хийх, зургийн даалгавар боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байршлийг тогтоох, зургийн даалгаварыг боловсруулж, хянуулан батлах шатандаа байна.



- 4 “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай” хууль болон холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд шаардлагатай нэг байршилд дахин төлөвлөлт хийх ажлын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг төслийн санхүүжилтийг шийдвэрлэх хүсэлтийг АЗДТГазарт хүргүүлээд байна. Хот суурин газрын дахин төлөвлөлтийн хууль дүрэм журмын талаар байгууллагын вэб сайт болон орон нутгийн телевизээр мэдээллийг хүргэж байна. Цаашид БХБЯам болон

холбогдох байгууллагуудтай хамтран иргэдэд мэдээлэл, ойлголтыг өгөх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Орон сууц нийтийн аж ахуйн чиглэлээр:

- Иргэдээс ирүүлсэн өргөлдөл гомдлыг тухай бүр үзэж шалган шийдвэрлэн ажиллаж байна.
- “Бадрах 70” СӨХолбоотой хамтран 2018 оны 05 дугаар сарын 26-ний өдөр 3-р багийн иргэдтэй уулзаж холбогдох хууль тогтоомжийн танилцуулга, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэх ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Захиалагчийн хяналтын ажил:

- Нийтийн эзэмшлийн 8 дугаар байрны гадна фасад дулаалгын ажилд гүйцэтгэлийн үе шатны хяналтыг хэрэгжүүлж байна. Ажлын явцын шалгалтаар илэрсэн зөрчилгүй. Ажлын явц 65%



- Сүмбэр сумын 100 хүүхдийн/канад/ цэцэрлэгийн барилга угсралтын ажил 2018.04.10-наас эхлэн дотор засал, шугамын ажлууд хийгдэж байна. Ажлын явц: 85%



- “Ус-Ду” ОНӨААТҮГазрын зуухны барилгын өргөтгөл шинэчлэлийн ажил үргэлжлэн хийгдэж байна. Өргөтгөл шинэчлэлийн цахилгаан хангамжийн ажилд мэргэжлийн мэргэшсэн инженерээр гэрээ байгуулан хяналтын ажлыг гүйцэтгэж байна. Ажлын явц: 95%



-
- Шивээговь сумын Соёлын төвийн барилгын зоорийн давхрын шугам сүлжээний ажлыг “Иргэдийн бүлэг” хийж гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулах улсын комисс 2018.05.18-ний өдөр ажиллсан.



Нэг цэгийн үйлчилгээгээр үзүүлсэн үйлчилгээ:

- Газар эзэмших эрх шилжүүлэх талаар эрх зүйн зөвлөгөө 20 иргэнд
- Газар өмчлөх эрх шилжүүлэх талаар эрх зүйн зөвлөгөө 33 иргэнд
- Газрын төлбөрийн талаар лавлагаа мэдээлэл 42 иргэнд тус тус өгсөн байна.
- Газар өмчилсөн иргэдийн бүртгэлээс лавлагаа мэдээлэл 88 иргэнд
- Газрын өв залгамжлын талаар эрх зүйн зөвлөгөө 6 иргэнд
- Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаар мэдээлэл 15 иргэнд
- Газрын харилцааны чиглэлээр гаргагасан гарын авлага тараах материал 34 иргэнд тус, тус өгч үйлчилсэн байна.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР